

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
02 ДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2018.01.26-2018.02.25/

2018 оны 02 дугаар
сарын 26-ны өдөр

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2018 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 2018 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

1.1. Монгол Улсын виз олголтын талаар:

Тайлант хугацаанд Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу хилийн боомтод виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан нийт БНХАУ-ын 1 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- Визийн шилжүүлэг-1

Нийт 1 гадаадын иргэнд виз олгож, визийн хуудасны үнэ болох 7300 төгрөгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Голомт банкны 1320000114 тоот дансанд, тэмдэгтийн хураамжийн 32.000 төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын 100110000941 тоот дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын 1446 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Орох чиглэлд:665

Гарах чиглэлд:781

1.2. Түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт:

Тайлант хугацаанд БНХАУ-ын 1 иргэнд түр ирэгчийн бүртгэл, хасалт хийж ажилласан байна.

ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 34 иргэнийг бүртгэж, 39 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

1.3. Гадаадын иргэдийн хяналт шалгалтын хүрээнд:

Тайлант хугацаанд Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн УБ-02/2018-002 тоот удирдамжийн дагуу гэр бүлийн шалтгаанаар Монгол Улсад оршин суух хүсэлт гаргасан БНХАУ-ын иргэн Eerdengmutu /1975 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр төрсөн, эрэгтэй, EA5023283 дугаарын паспорттай/-ийн оршин суугаа хаягаар очиж ажил байдалтай танилцан, байцаагчийн дүгнэлтийг холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

Нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн үндэслэлээр торгуулийн арга хэмжээ авч, албадан гаргагдсан Тайландын Вант улсын 5, Австрали Улсын 1 нийт 6 иргэний зөрчлийг шалган шийдвэрлэсэн тухай материалыг Өмнөговь аймгийн Прокурорын газраар хянуулсан болно.

Тус газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн баталсан ӨМ-2018/02 тоот удирдамжийн хүрээнд 02 дугаар сарын 21-ний өдрөөс 03 дугаар сарын 23-ны өдөр хүртэлх хугацаанд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо сум, Дундговь аймгийн Адаацаг, Айраг, Баянжаргалан, Говь-Угтаал, Гурвансайхан, Сайнцагаан сумдын нутаг дэвсгэрт хийх хяналт шалгалтыг эхлүүлээд байна.

1.4. Монгол Улсаас албадан гаргасан талаар:

БНХАУ-ын иргэн BAO JINLONG нь /1982 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр төрсөн, эрэгтэй, E51541900 дугаарын паспорттай/ Өмнөговь аймгийн Шивээхүрэн боомтын хилийн 573 дугаар тэмдгээр Монгол Улсад орох хил нэвтрэх баримт бичиггүйгээр улсын хилийг нэвтэрсэн хэрэг үйлдэж, тус аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 23 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 19.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу 8000 /найман мянга/ нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 8.000.000 /найман сая/ төгрөгөөр торгох ялаар шийтгүүлсэн.

Тус иргэнийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37.1.11 дэх хэсэгт зааснаар Монгол Улсаас албадан гаргасан болно.

1.5. Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Тайлант хугацаанд ГИЭЗБТХ-ийн 22 дугаар зүйл 22.1.6, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолын 4.1 дэх заалтуудыг үндэслэн БНХАУ-ын 2 иргэн, Хөх хотын консулын газраас олгосон олон удаагийн визинд гарын үсэг зурж баталгаажуулаагүй визтэй 1 иргэн, нийт 3 иргэнийг хилээр оруулаагүй буцааж ажилласан.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

2.1. Захиргааны чиглэлээр хийсэн ажил

Газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд үүссэн баримтыг үдэж, цэгцлэн хадгаламжийн нэгж үүсгэн архивт бүртгэн хүлээн авч ажиллалаа.

Хүний нөөцийн шинэчлэгдэн гарсан програмд нийт 18 албан хаагчийн мэдээллийг оруулж бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг гарган Төрийн албаны зөвлөлийн Өмнөговь аймаг дахь салбар зөвлөлд хүлээлгэн өгч ажилласан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд оруулах саналыг нийт албан хаагчдын хурлаар хэлэлцэн 2018 оны 02 дугаар сарын 08-ны өдөр 07 дугаар илтгэх хуудсаар Эрх зүй, гадаад харилцааны хэлтэст хүргүүлсэн болно.

Сар шинийн баярыг тохиолдуулан хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, тээврийн хэрэгслийн бэлэн байдлыг ханган, болзошгүй гал, цахилгаан, дулааны ослоос урьдчилан сэргийлэх ажлуудыг зохион байгуулж гарсан зөрчилгүй болно.

Албан хаагчдын төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдэл шинээр олгуулах болон нэмэгдүүлэх санал, орон сууцны судалгааг гарган Тамгын газарт хүргүүлж ажиллалаа.

2.2. Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/- 2
 - Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо- 0
 - Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо /Ерөнхий газарт/-2
 - Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
 - Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-1/
 - Ерөнхий газраас ирсэн бичиг-1
 - Ерөнхий газарт явуулсан бичиг /албан тоот, илтгэх хуудас-4/
 - Бусад байгууллагад хүргүүлсэн бичиг /албан тоот-9/
 - Бусад байгууллагаас ирсэн бичиг-7
 - Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

2.3. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тус Газрын 02 дугаар сарын шилэн дансны мэдээллийг шивж, мэдээг Санхүүгийн хэлтэс, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Хөрөнгийн дахин үнэлгээ хийх ажлыг зохион байгуулахтай холбогдуулан байгууллагын даргын 2018 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/19 дугаар тушаалыг үндэслэн тус газрын хөрөнгийн дахин үнэлгээний ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/02 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.

Энэ оны 02 дугаар сард 18 албан хаагчид 12.790.038 төгрөгийн цалин олгож, татварт 1.247.036 төгрөг, нийгмийн даатгалд 3.516.542 төгрөгийн гүйлгээ гаргаж ажилласан.

2.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Тайлант хугацаанд дотоод сүлжээний e-office програм болон Өвөрхангай аймгийн мэргэжилтний сүлжээнд доголдол гарсныг тухай бүр нь янзлан сүлжээний хэвийн ажиллагааг ханган ажиллалаа.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР